

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

┌ Хувьцаа шилжүүлэх тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 болон “БИДИСЕК” ХК-ийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “БИДИСЕК” ХК-ийн хөрөнгөөр худалдан авсан Д.Данзангийн 7-610111 тоот дансанд байгаа “Дархан хөвөн” ХК-ийн 9924 /есөн мянга есөн зуун хорин дөрвөн/ ширхэг хувьцааг тус компанийн 7-999998 тоот дансанд шилжүүлэн бүртгэсүгэй.

2. Тогтоолоор өгсөн үүргийг биелүүлэн ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/-д, “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-д тус тус даалгасугай

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Х.БУМ-ЭРДЭНЭ